

**МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ (SECIM)
(2020 оны жилийн эцсийн байдлаар)**

	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл						
1	Төслийн нэр: Шийдвэрийн дугаар: Хөдөлмөр Нийгэм Хамгааллын сайдын 2016 оны 9 сарын 29-ний А/153 тушаал	Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл Бүрэлдэхүүн хэсэг 2: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл GCP/MON/014/EC Төслийн зорилго: Уул уурхайн бус салбарт чанартай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, Монгол улсын нөөц боломж, давуу талд тулгуурлан хувийн хэвшлийн салбарт ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах.						
2	Санхүүжилтийн үүсвэр	Буцалтгүй тусламж : Европын Холбоо НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага						
3	Хэрэгжүүлэгч байгууллага:	Үндсэн хэрэгжүүлэгч: НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам НҮБ-ын Аж үйлдвэрийн байгууллага						
	Хэрэгжих нийт хугацаа	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөөх Фермерүүдийн Холбоо Монголын Махны Холбоо ТББ Монголын Сүүний Үндэсний Зөвлөл Хөдөө аж ахуйн их сургууль Ургамал, газар тариалангийн хүрээлэн						
		2016 оны 2 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сар, 1 үе шаттай Газар зүйн хамрах хүрээ: Дархан-Уул, Дорнод, Төв, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймгууд						
4	Төслийн зорилтууд	Төслийн зорилт Мал аж ахуй болон хүнсний ногооны салбарын нэмүү өртгийн сүлжээнд хувийн хэвшлийн салбарын ажлын байр бий болгох нөхцөлийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх Зорилго 2.1: Мах, махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг бүрдүүлэх. Зорилго 2.2: Сүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх Зорилго 2.5: Сүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх						
5	Зардал	Тайлант 2020 оны төслийн гүйцэтгэл, мян.евро						
		<table border="1"> <thead> <tr> <th>Төсөв (2020)</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Евро 936,04</td> <td>Евро 861,04</td> <td>88%</td> </tr> </tbody> </table>	Төсөв (2020)	Гүйцэтгэл	Хувь	Евро 936,04	Евро 861,04	88%
Төсөв (2020)	Гүйцэтгэл	Хувь						
Евро 936,04	Евро 861,04	88%						
	Төслийн зорилт	Ажлын биелэлтийг доорх талбарт бичнэ						
	<i>Зорилго 2.1: Мах, махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг бүрдүүлэх</i> Хүрэх үр дүн 2.1.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чанар, гарал үүслийг мөшгөх тогтолцоог сайжруулах Хүрэх үр дүн 2.1.2 Зах зээлд албан ёсоор нэвтрэх нөхцөлийг сайжруулах	Нэгж малын махны гарцыг нэмэгдүүлэх зорилгоор хурга, бярууг цахилгаан соронзон долгионы багаж ашиглан үрийн сувгийг зайнаас төөнөж, таслах технологийг 70 орчим малчидтай хамтран Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан, Төв аймгуудад түгээн дэлгэрүүлж байна. Нийт 1,805 хурганы үр дамжуулах сувгийг төөнөх- таслах аргаар хөнгөлөн, эхээс нь ялган бэлчээрээр амьдын жинг нь нэмэгдүүлж 10 дугаар сард мал төхөөрөх үйлдвэрт нийлүүлж, махыг нь экспортлов. Энэхүү технологийг хэрэгжүүлсний үр дүнд бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд бойжуулсан хургыг эдийн засгийн эргэлтэнд түргэн оруулах боломж бүрдэж, махны экспортыг нэмэгдүүлэн, махны НӨС-г хөгжүүлэх боломж бий болсон. Тус аргын эдийн засгийг тооцооллыг хийж танилцуулсан. Эр хургыг эрт нядалгаанд оруулж борлуулснаар бэлчээр, ус, хөдөлмөрлөх өртөг 50%-иар буурсан ч малчны авах орлого буурахгүй. Харин малчид ноосны борлуулалтаас олох орлогоо алдах бөгөөд энэ нь жилд нэг хонинд 2750 орчим төгрөг ногдож байгаа явдал юм. Эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор “Махны үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж дуусгасан. Засгийн газраас						

<p>Хүрэх үр дүн 2.1.3 Махны үйлдвэрлэлийн дэд салбарт аймаг, сумын түвшинд бизнесийн үйлчилгээний ажилтан, технологич нарт зохистой хөдөлмөр эрхлэлт чадварыг бий болгох</p>	<p>энэхүү зохицуулалтыг баталснаар гар аргаар төхөөрсөн малын махыг хэрэглэгчдэд шууд борлуулахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй хяналтын тогтолцоог бий болгож, улмаар нядалгааны газрын үйлдвэрлэлийн гарц, хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлснээр махны өртгийн сүлжээнд илүү зохицсон ажлын байр бий болгоход хувь нэмрээ оруулах юм.</p> <p>Төслийн 5 аймгийн 14 оролцогчдод “Мал нядалгааны газруудын сайн туршлага” онлайн сургалтыг зохион байгуулав. АХБ-ны ХАА-н өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөлтэй хамтран "Нядалгааны технологи, мал эмнэлэг, ариун цэврийн сургагч багш" сургалтаар 9 сургагч багш бэлтгэв. Сургалтад хамрагдсан бүх оролцогчид үндэсний хэмжээнд сургалт явуулах чадвартай боллоо.</p> <p>Малын болон мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийн хэлхээн дэх махны гарал үүслийг мөшгөх тогтолцоог Монголд анх удаа блокчэйн суурьтай болголоо. Блокчэйн суурьтай болгоно гэдэг нь мэдээллийг үнэн зөвөөр найдвартайгаар тараан байршуулж хадгалж байна гэсэн үг юм.</p> <p>Мал төхөөрөх үйлдвэрийн технологийн дамжлага дотор мөшгөх системийг үргэлжлүүлэх боломж бий болгох махны үйлдвэрийн дотоод хяналтын мэдээллийн системийг хөгжүүлж Төв аймгийн Баяндэлгэр суманд байрлах “Баяндэлгэр хүнс” компанид нэвтрүүлсэн. Өмнө нь мал нь мах байхад мөшгөх тогтолцоо үргэлжилж, хэний, ямар зүсмийн, хэдэн настай, эм тариа вакцинд хэдийд хамрагдсан мал байна гэдгийг мөшгөж болдог ч, мал нь боловсруулах үйлдвэрт орж хэдэн хэсэг мах болох үед үргэлжлүүлэн мөшгөх боломжгүй байдаг байсан. Цаашид энэ системийг мал эмнэлгийн нэгдсэн систем буюу мал эмнэлгийн гэрчилгээ, баталгаажуулалтын цахим системтэй холбохоор төлөвлөсөн юм. Ингэснээр хэрэглэгчид малчны хотноос мал төхөөрөх үйлдвэр, дэлгүүр, хэрэглэгч хүртэл мөшгөх боломжтой, хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн хэрэглэх бололцоог бүрдүүлэх юм.</p> <p><i>МУ-ын Ерөнхийлөгчийн шуурхай арга хэмжээ авч ажиллах хүсэлтийн дагуу төслийн баг 2020.10.19 өдөр төслөөс өмнө нь нэвтрүүлсэн ар хуулах (SFF) төхөөрөмж болон мэргэжлийн хутга, хэрэгслийг ашиглан мал төхөөрөх сургалтад нийт 50 ахлах офицеруудыг хамруулан сургагч багшаар бэлтгэж, тэд цааш нь 3000 офицерыг сурган Ерөнхийлөгчийн тушаалаар 6 аймагт нийт 40000 тн махыг 40 хоногт бэлтгэсэн. Бэлтгэсэн махыг Хятад улсад экспортолсон. Энэ ажлын үр дүнд 6 аймгийн малчин айл өрх дэмжлэг авч, нийт 5,5 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, зудын аюулд өртөхөөс сэргийлж чадсан.</i></p> <p>Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, мах боловсруулах болон сав баглаа боодлын технологи зэрэг сэдвээр интерактив сургалтын материалыг бэлтгэж байна. “Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах нийтлэг үйлчилгээ” -ний зураглал болон үнэлгээг хийв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-85%</p>
<p>Зорилго 2.2: Сүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх</p> <p>Хүрэх үр дүн 2.2.1: Сүү үйлдвэрлэх цуглуулах, хадгалах, боловсруулах, зах зээлийнд нийлүүлэх тогтолцоо болон хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах</p> <p>Хүрэх үр дүн 2.2.2: Чанар сайтай сарлаг, ингэ, ямаа, хонины сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж зах зээлийг өргөтгөх</p> <p>Хүрэх үр дүн 2.2.3: Мэргэжлийн зөвлөх багийг байгуулж сургах</p>	<p>МХХолбоотой ажил гүйцэтгэх гэрээ байгуулан “Чанарт суурилсан төлбөрийн системийн туршилт хийх, аргачлал” боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>Сүү боловсруулах томоохон үйлдвэрүүд болох “Сүү” ХК, “АПУ” ХК болон ТЭСО, “Витафит”, “Монфреш” ХХК Улаанбаатар хотыг хүрээлсэн 250 км-ын тойргоос сүү цуглуулдаг. Үүнээс цааш сүү цуглуулах дэд бүтэц хөгжөөгүй. Өвлийн улиралд сүүний гарц бага тул эдгээр компани сүү цуглуулах хүйтэн хэлхээг (cold chain) хөгжүүлэхийн оронд, жилд дунджаар 6000 тонн хуурай сүүг (48 сая литр шингэн сүүтэй тэнцэх хэмжээний) импортоор оруулж ирж өвөл хаврын улиралд сэргээн хэрэглэдэг. Тиймээс төслийн баг 250 км-ын тойргоос цааш аж төрдөг малчдаас сүү цуглуулах, боловсруулах, ашиглах загварыг гаргаж ажилласан юм. Үүний тулд малчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, тэднийг түшиглэн жижиг сүү боловсруулах үйлдвэрүүд сумын төвд байгуулагдахад дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд тэдгээр шинэ үйлдвэрүүд аарц, цөцгийн тос гэх мэт, хадгалалт, тээвэрлэлт даах бүтээгдэхүүнийг нэг стандартаар боловсруулдаг боллоо. Сумын төвийн жижиг боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг нэг “брэнд” нэрийн дор аймгийн төвд борлуулах болон үндэсний томоохон үйлдвэрүүдэд нийлүүлэх маркетингийн байгууллагыг чадавхжуулсан нь энэ чиглэлд хийсэн ажлын нэгэн чухал хэсэг байв. Олон жижиг үйлдвэрүүд нэгдэж хангалттай хэмжээний аарц, цөцгийн тос үйлдвэрлэж чаддаг болсноор үндэсний томоохон үйлдвэрүүд нэг цэгээс ирж бүтээгдэхүүн татдаг болсон. Энэ загварыг алслагдсан бүс болох Ховд, Хөвсгөл, Дорнод аймгуудад хэргэжүүлсэн юм.</p>

		<p>Тариалангийн бүс нутагт тариалангийн үйлдвэрлэлийг ЭМАА-н үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх шаардлагатай. Иймд эдгээр бүсэд ЭМАА, сүүний ферм байгуулах ажил ид өрнөж байна. Төслийн дэмжлэгтэйгээр сүүний ферм байгуулах гэж байгаа хүмүүст зориулсан анхны 5 цуврал видео хичээлийг боловсрууллаа.</p> <p>Монгол Улсын хэмжээнд Хүнс, технологийн политехникийн коллежээс бусад МСҮТ-үүдэд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийн ажилтан болон мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ажилтан бэлтгэдэггүй байна.</p> <p>Төслийн хүрээнд “Эрдэнэ” МСҮТ-тэй хамтран багш нарыг бэлтгэн чадавхжуулж, шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжөөр ханган, сүү, сүүн бүтээгдэхүүн болон мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийн ажилтан бэлтгэх ангийг 2018 онд нээлтээ хийснээс хойш 3 жил дараалан элсэлт аваад байна. Энэ хугацаанд 33 оюутан суралцаж төгссөнөөс 25 нь ажлын байртай болоод байна.</p> <p>Төсөлд хамрагдсан малчид 2020 онд нийт 629,880 литр сүү сааж сүү боловсруулах цехэд нийлүүлсэн байна.</p> <p>2020 оны 11-р сард болсон ДСБББ-ын удирдах зөвлөлийн хурлын үеэр Монгол Улс, МСББҮНХ нь ДСБББ-ийн саналын бүрэн эрхтэй гишүүнээр сонгогдсон нь Монгол Улсын хувьд хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошгыг сайжруулах, маркетинг, экспортын шинэлэг шийдэл гаргах үүд хаалга нээгдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-82%</p>
<p>Зорилго 2.3: Ноос, ноолууран бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг бүрдүүлэх.</p>		<p>Ноосны чанарыг сайжруулах зорилгоор цахилгаан машинаар хонины ноосыг хяргах ажлыг АУО малчдын дундын хоршоо, ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлсэн нь төслийн үр шимийг хүртэгчид болон хамтран ажиллагсад хамгийн их танигдаж сайшаагдсан арга хэмжээний нэг болсон. Хонины ноосны чанарыг сайжруулах арга хэмжээнд тулгуурлан нэгэн төрлийн ноосон түүхий эд хэрэглэж тухайн нэмүү өртгийн сүлжээнд ээрэх ажиллагаанд аппаратын ээрмэлийн үйлдвэрлэл болон сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулалтын ажиллагааг боловсронгуй болгох процесстэй холбож чадсан.</p> <p>НҮБАҮХБ-ын сургагч багш нарын удирдлагаар ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт чиглэсэн сургагч багш бэлтгэх эрчимтэй сургалтуудын дүнд ХҮСХХ-д үндэсний экспертүүдийн нөөц бий болгов.</p> <p>Дундговь, Ховд аймгийн 6 сумын хоршоод ноос бэлтгэх, нийлүүлэх өртгийн сүлжээнд оролцов. Нийт 87.1 тн ноосыг машинаар хяргаж бэлтгэн, үндэсний 5 үйлдвэрт нийлүүлсэн. Малчдын амьжиргаанд нийт 143.7 сая.төг төвлөрүүлэн, Засгийн газраас 130.6 сая.төгрөгний урамшуулал олгов. Хоршоод болон үндэсний үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэв.</p> <p>Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад үйлдвэрт худалдсан ноосны үнэ 60,6%-иар, нийлүүлсэн ноосны хэмжээ 76,4%-иар нэмэгдсэн.</p> <p>Бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон бүтээлч ур чадварыг сайжруулах зорилгоор “Сүлжмэл бүтээгдэхүүний загвар, зохион бүтээлт” сургалтыг 2020.09.28-10.06-ны өдрүүдэд явуулав. Сургалтад 10 сүлжих үйлдвэрийн 18 загвар зохион бүтээгч оролцов. Сургалтын дүнд суралцагчдын загвар зохион бүтээлт, сүлжих технологийн талаарх мэдлэг, ур чадвар 29%-иар сайжирсан.</p> <p>Төслийн туслалцаатайгаар бүрэн тоноглогдсон “Текстилийн гүйцэтгэн боловсруулалтын инкубатор төв”-ийг ХҮСХХ-д байгуулснаар хувийн хэвшил, оюутан, үйлдвэрийн мэргэжилтнүүдэд зориулсан туршилт, сургалтын ажлуудыг гүйцэтгэж байна. ХҮСХХ нь орчин үеийн Муудл дээр Сургалт удирдах системтэй болсон. Муудл хөгжүүлэлт хийсэн байгууллагаас техникийн ажилтнуудад зориулсан “е-Сургалтын арга зүй” сургалтыг ХҮСХХ-ийн 5 сургагч багш нарт 2 удаа 2 долоо хоногийн хугацаанд сэдвээр явуулав. ХҮСХХ-ийн институцийн чадавхи е-Сургалтыг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр бэхэжсэн. Тус хүрээлэн нь онлайн болон холимог сургалтыг явуулах боломжтой болсон.</p> <p>Интерактив сургалтын материалуудыг боловсруулсан бөгөөд гарын авлага, онлайн хэлбэрээр хэрэглэх боломжтой: https://learning.unido.org ; https://learning.rdili.edu.mn</p> <p>Олон улсын мэдлэг, ур чадварыг нэвтрүүлэх институц ба мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх зөвлөхүүдийн нөөц бүрдүүлж 22 мэргэжилтэн бэлтгэсэн. Олон улсын эксперт Лайнус Ву, үйлдвэрийн процесс бүрийн бэнчмаркаар</p>

		<p>дамжуулан чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг хийж, цаашид сайжруулахын тулд бэнчмаркинг хийх үнэлгээний ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>Дайвар бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээсэн ноосон бүтээгдэхүүний экспортын зах зээл байгаа бөгөөд ДСБББ-аар дамжуулан Монголын үйлдвэрт бизнес саналыг тавьсан боловч Ковид-19-ын хөл хорионоос шалтгаалж, НҮБАҮХБ-ын төв байрнаас үүнд дэмжлэг үзүүлэх ажлыг батлах үйл явц удаашран, улмаар энэхүү ажил цуцлагдсан болно.</p> <p style="text-align: right;">ХШҮ- 82%</p>
	<p>Зорилго 2.4: Арьс, ширний нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг бүрдүүлэх.</p>	<p>Гарсан үр дүн: Дотоод нөөц боломжид тулгуурласан, хямд төсөр, түгээн дэлгэрүүлэх боломжтой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга бүхий эсгэлтгүйгээр Арьс шир хуулах технологийг арьс ширэн түүхий эдийн чанар сайжруулах ажлын хүрээнд анх эхлэн, түгээн дэлгэрүүлж ажиллалаа. Энэхүү ажлын зохион байгуулахад ХХААХҮЯ хамтран ажилласаар ирсэн ба үндэсний хэмжээнд бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээний чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд түгээн дэлгэрүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн арьс ширний салбарын оролцогч талууд, тэр дундаа боловсруулах үйлдвэрүүдэд зориулсан олон улсын чадавхжуулах сургалтуудыг НҮБАҮХБ-ын олон улсын болон үндэсний зөвлөхүүдтэй хамтран зохион байгууллаа. Эдгээр ажлуудыг амжилттай хэрэгжүүлж, зорилтот үр дүнд хүрэхэд МАШҮХ, АҮО малчдын дундын хоршоо зэрэг байгууллагууд чухал үүрэгтэй оролцсон.</p> <p>Арьс шир үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, гүйцэтгэлийг дээшлүүлэх зорилгоор төсөл нь НҮБАҮХБ-ын олон улсын арьс ширний эксперт, LWG-ийн тэргүүлэх аудитор Висванатан Мунусамитай хамтран Дархан Минж ХХК-ний арьс шир боловсруулах үйлдвэрийг LWG Байгаль орчны баталгаажуулалт авахад нь мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн. Ковид-ын нөхцөл байдлаас шалтгаалан аудит хийлгэх ажил шийдэгдэнэ.</p> <p>Арьсан бүтээгдэхүүний уралдааныг эрэгтэй ба эмэгтэй цүнх, жижиг эдлэл, гутал зэрэг чиглэлээр зохион байгуулсан. Шалгарсан бүтээгдэхүүнийг 12-р сард зохион байгуулагдах загварын арга хэмжээний үеэр танилцуулахаар төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахлаас шалтгаалж хойшлогдсон.</p> <p>Гутлын зохион бүтээлтийн багшийн гарын авлагыг 2018-2019 онд боловсруулж 2020 онд монгол хэл рүү орчуулсан. "Гутлын зохион бүтээлт" курсийг гутлын үйлдвэрийн дизайнеруудад түгээж дадлагажуулах сургалт явуулж байна.</p> <p>Арьс ширний ээлтэй үйлдвэрлэл сургалтын хөтөлбөрт нэгтгэн баяжуулсан "Арьс ширний чанарыг сайжруулах" сургалтын модулиудыг АРМОНО, ХҮСХХ-нд хүлээлгэн өгсөн.</p> <p>НҮБАҮХБ-ын Арьс ширний сорил шинжилгээ 5-модуль сургалтын материалыг АРМОНО корпорацийн лабораторийн мэргэжилтнүүдтэй хамтран цахим сургалтын мэргэжилтэн Монгол хэл рүү хөрвүүлсэн. Тус сургалт 395 слайд, 195 зураг, график, 21 тайлбар видео бичлэг, 7 кейс дасгал ажил, 35 өөрийгөө сорих тестээс бүрдэнэ. "Онлайн сургагч багш бэлтгэх" 2 долоо хоногийн сургалтаар АРМОНО корпорацийн 5 мэргэжилтнийг бэлтгэсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-80%</p>
	<p>Зорилго 2.5: Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд зохистой хөдөлмөр эрхлэлт, орлого олох боломжийг нэмэгдүүлэх</p> <p>Хүрэх үр дүн 2.5.1: Хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд оролцож өрхийн болон жижиг аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн болон зохистой ноу-хау арга туршлага нэмэгдүүлэх</p> <p>Хүрэх үр дүн 2.5.2: Хүнсний ногоо хурааж нөөцлөх төвүүдийг хураасан ногоогоо арчлах хадгалахад шаардлагатай</p>	<p>Орон нутагт хүнсний ногоо боловсруулах хүчин чадал, боломж нэлээд хязгаарлагдмал байдаг. Иймд төсөл нь хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээнд оролцогчдын бизнесийн үйл ажиллагааг сайжруулахын тулд ногоочдын бүлгийг байгуулах, нөөцийг нэгтгэх, гэрээт тариалалт зэрэг ажлуудад онцгой анхаарч ажилласан. Төслийн оролцооны үр дүнд 71 гишүүнтэй 6 хоршоо, 81 гишүүнтэй 9 бүлэг төслийн зорилтот аймгуудад бий болсон. Эдгээр бүлгүүд нь Улаанбаатар хотод боловсруулах үйлдвэр болон агуулахтай гэрээтэй ажиллаж байна.</p> <p>Агшин зуур хөлдөөх технологийг Улаанбаатар болон Хөвсгөл аймгуудад нэвтрүүлсэн. Монгол орны цаг уурын онцлогоос хамаарч, тариалалтын ганцхан улиралтай, хүнсний ногоог 8 сарын турш хадгалах хэрэгцээтэй манай орны нөхцөлд хүнсний ногоог энэхүү технологийн тусламжтай шим тэжээл, эрүүл мэндийн ашиг тусыг урт хугацаанд хэвээр хадгалах нь хамгийн зөв шийдэл юм. 2017 оны байдлаар улсын нийт хүнсний ногооны хэрэгцээний 0.6 хувийг импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүн эзэлж байв (970 тонн шинэ хүнсний ногоо, 700 тонн хөлдөөсөн ногоо). Импортыг орлох хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод Газар Шим ХХК, Хөвсгөл аймгийн Хөвсгөл центр ХХК-тай хамтран ажиллаж тус агшин зуур хөлдөөх технологийг нэвтрүүлсэн.</p>

	<p>тоног төхөөрөмж (сортолж ялгах, ангилах, савлах, хөргөх) агуулах, бага оврын боловсруулах тоног хэрэгслээр хангах сайжруулах Хүрэх үр дүн 2.5.3: Хураасан хүнсний ногооны алдагдлыг бууруулахын тулд боловсруулах арга нэвтрүүлэх, хадгалах хугацааг уртасгах аргыг сайжруулах.</p>	<p>Хөвсгөл центр ХХК төмс, лууван, шар манжин, амтат чинжүү, байцаа, хятад байцаа зэрэг 10 төрлийн хөлдөөсөн хүнсний ногоо, мөн хөлдөөсөн гишүүгэнэ, тарвасыг үйлдвэрлэж эхлээд байна. Ингэснээр фермерүүд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой болж байна. Одоогийн байдлаар тус компани орон нутгийн худалдааны төвүүдэд хөлдөөсөн бүтээгдэхүүнийг нийлүүлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын дэлгүүрүүдэд нийлүүлэлтийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.Тус технологийг хэрэглэснээр 8 шинэ ажлын байр бий болж, 40 ногоочид ногоогоо тус компанид нийлүүлж, орлого олж байна.</p> <p>Газар Шим ХХК шилтэй холимог салат үйлдвэрлэлийн гол орц болох амтат чинжүүг Хятад улсаас импортолдог ба 20 төрлийн шилтэй ногоог дотоодын зах зээлд нийлүүлдэг. Амтат чинжүүг удаан хадгалах хамгийн боломжит арга бол хөлдөөх юм. Агшин зуур хөлдөөх технологийг хэрэглэснээр тус компани нь орон нутгийн ногоочдоос амтат чинжүүг их хэмжээгээр бөөнөөр худалдан авч, хөлдөөж, жилийн турш ногооны саладыг үйлдвэрлэх боломжтой болсон. Компани нь Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 250 ногоочидтой гэрээ байгуулж, амтат чинжүү худалдан авч байна. Ингэснээр амтат чинжүүний дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, ногоочдод нэмэлт орлого олоход эерэг нөлөө үзүүлж байна.</p> <p>Төсөл нь хүнсний ногооны хадгалалтын нөхцөлийг сайжруулж, ургацын дараах алдагдлыг багасгах үүднээс орон нутгийн төрийн болон хувийн байгууллагуудын санаачилсан хүнсний ногооны зоорь барих ажлуудад дэмжлэг үзүүлсэн. Энэ ажлын хүрээнд Сэлэнгэ, Төв аймгуудын 2 аж ахуйн нэгжид бизнесийн төлөвлөгөө боловсруулахад нь техник, арга зүйн зөвөлгөө өгч ажилласан. Фермерүүдийн хүнсний ногоо үйлдвэрлэлийн технологийн мэдлэг болон хүчин чадлыг сайжруулахын тулд төслийн хэрэгжилтийн 6 аймагт 60 гаруй фермерүүдэд техникийн зөвөлгөө, талбайн сургалтуудыг зохион байгуулсан. Хүнсний ногооны үйлдвэрлэл болон өртөгийг нэмэгдүүлэх замаар орон нутагт ажлын байруудыг нэмэгдүүлэхийн тулд боловсруулах нэгжүүдийг байгуулах ажлыг дэмжиж ажилласан.</p> <p>Технологийн болон маркетингийн мэдлэг мэдээлэл дутмаг байдгаас ногоочид зах зээл дээр бүрэн өрсөлдөхүйц байж чаддаггүй ба энэ нь бизнесээ өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх олон боломжуудыг алдахад хүргэдэг. Иймд төслөөс хэрэгцээт тоног төхөөрөмжөөр дэмжин, мөн ногоочдыг технологийн болон маркетингийн сургалтууд, зөвлөх үйлчилгээнд хамруулснаар, бүтээгдэхүүний нэр төрөл олширч, ажлын үр бүтээмж, борлуулалт, орлого нэмэгдэж, орон нутагт ажлын байрууд шинээр бий болсон. Жишээ нь: Төслөөс тоног төхөөрөмжийн болон сургалт, зөвлөх үйлчилгээний дэмжлэг авсан Дархан-Уул аймгийн Буян-Да хоршоо нь хүнсний ногоо боловсруулах жижиг цехийг байгуулж, төрөл бүрийн ногооны шүүс, нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрт болон орон нутгийн зах зээлд нийлүүлж байна. Төсөлд хамрагдсанаас хойш тус цехэд 10 шинэ ажлын байр бий болсон.</p> <p style="text-align: right;">ХШҮ-86%</p>
7	<p>Дүгнэлт дутагдал, асуудлууд (ололт, анхаарах)</p>	<p>Ололт:</p> <p>Монгол улсад анх удаа хүнсний ногоог чанарыг нь алдагдуулахгүй агшин зуур хөлдөөж хадгалах технологийг амжилттай туршиж Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод тус төхөөрөмжийг ажиллуулж байна.</p> <p>Махны НӨС хөгжүүлэх ажлын хүрээнд махны гарцыг нэмэгдүүлэх зорилгоор хурга, бярууг цахилгаан соронзон долгионы багаж ашиглан зайнаас төөнөх аргаар хөнгөлөх технологи нэвтрүүлж 8 сартай хурганы махны гарц 18 сартай төлөгнийхтэй адил болж, эдийн засгийн эргэлтэд хурдан ороход төслийн ашиг хүртэгчдэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Малын болон мах, махан бүтээгдэхүүний үнэ цэнийн хэлхээн дэх махны гарал үүслийг мөшгөх тогтолцоог Монголд анх удаа блокчэйн суурьтай болголоо. Энэ тохиолдолд махны гарал үүсэл буюу малын нас, зүс, хүйс, эм тариа, вакцин хийлгэсэн хугацаа, малчны нэр, байршил, хаяг болон махны үйлдвэрийн дотоод хяналтын мэдээллийн системийн мэдээлэл буюу мал нь аль махны үйлдвэрт хэзээ боловсруулагдсан, махны ангилаллын код гэх мэтчилэн мэдээллийг блокчэйн технологиор дамжуулан хадгалж байгаа юм.</p> <p>Мал төхөөрөх үйлдвэрийн технологийн дамжлага дотор мөшгөх системийг үргэлжлүүлэх боломж бий болгох махны үйлдвэрийн дотоод хяналтын</p>

		<p>мэдээллийн системийг хөгжүүлж Төв аймгийн Баяндэлгэр суманд байрлах “Баяндэлгэр хүнс” компанид нэвтрүүлээ.</p> <p>Төслийн сүүлийн жил энэ хэцүү цаг үетэй давхацсанаар төслийн ололт амжилтыг бататгахаас гадна, үүссэн шинэ нөхцөл байдалд дасан зохицоход хамтрагч байгууллагуудаа дэмжих шаардлага гарсан юм. Мөн нөхцөл байдлыг бодитоор дүгнэж, төслийн эцсийн үнэлгээ хийх төсвийг Ковид-19 цар тахалд нэрвэгдсэн хүнс боловсруулах үйлдвэрүүдэд тусламж болгон олгох хүсэлтийг санхүүжүүлэгч байгууллага болох Европын Холбоо түргэн шуурхай шийдвэрлэн өгсөн. Ингээд нийт 134 сая төгрөгийн дэмжлэгийг 6 жижиг боловсруулах үйлдвэрт Монголын хүнсчдийн холбооны эрсдэлийн сангаар дамжуулан хүргэсэн. Сонгогдсон 6 жижиг үйлдвэр (мах боловсруулах-2, сүү боловсруулах-3, хүнсний ногоо боловсруулах-1) энэхүү дэмжлэгээр хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдээ авч, цар тахлын хүнд цаг үед үйл ажиллагаагаа 1-3 сар хэвийн явуулах боломжтой болсон. Мөн Монголын хүнсчдийн холбооны эрсдэлийн сан байгуулах үйл ажиллагааг дэмжин 10 сая төгрөгийн тусламж олгосон. Энэхүү эрсдэлийн сан нь цаашид жижиг үйлдвэрүүдэд давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед дэмжих гол зорилготой юм.</p> <p>НҮБАҮХБ- аас “Ковид-19 цар тахал Аж Үйлдвэрлэлийн салбар дахь аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох судалгаа” хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дутагдал</p> <p>Ковид19 цар тахлын нөлөө 2019, 2020 оны үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлсэн боловч, төслийн баг хамт олон боломжит бүх үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж шийдвэрлэсэн.</p> <p>Анхаарах асуудлууд</p> <p><i>-ДМАЭМХБ-аас гаргасан зааврын дагуу өвчингүй бус/хамгаалагдсан аж ахуй байгуулах тогтолцоог бий болгоход ХХААХҮЯ-ны удирдамж, дэмжлэг, оролцоо зайлшгүй шаардлагатай байна.</i></p> <p><i>-Төслийн хүрээнд бий болсон Сүүний НӨС-дэх хүйтэн хэлхээг бэхжүүлж өргөжүүлэхэд ХХААХҮЯ-наас бодлого үйл ажиллагаагаар дэмжих,</i></p> <p><i>-Төслийн хүрээнд бий болсон сайн туршиллагуудыг төслийн аймгуудад болон бусад аймгуудад дэлгэрүүлэхэд ЖДҮХС –ийн зээл, сургалт мэдээллээр дэмжих.</i></p>					
8	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ХХААХҮЯ, ХНХЯ, аймгуудын ХХААГ, МЭГ, малчдын хоршоод, жижиг, дунд бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод, хүрээлэнгүүдийн уялдаа холбоог “Хангалттай” гэж дүгнэж байна.					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ):	Биелэлт дундаж (2020)	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		83.0%	85	82	82	80	86
10	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ ЗГХЭГ-ын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ дүгнэлт, өөрийн үнэлгээ					

	Зорилтын тоо	Гүйцэтгэл	Биелэлт дундаж
2.1 Махны НӨС	35	28	80%
2.2 Сүүний НӨС	17	14	82%
2.5 Хүнсний ногооны НӨС	28	24	86%
Ерөнхий биелэлт	80	66	82.7%